



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/Ам

Мандатгүй

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 2.1.6, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.5.3.4, сумын засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.5.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын биет бус өв тээгч морин хуурч, хөгжмийн зохиолч Б.Эрдэнэбаярын аялгуу, Ж.Дашзэвгийн шүлэг "Алтан нутаг" сумын сүлд дуунд шинэчилсэн хөгжмийн найруулга бичлэг хийлгэхэд дэмжлэг үзүүлсүгэй.

2. "Алтан нутаг" сүлд дууг олон нийтийн арга хэмжээ, баяр ёслолын нээлт хаалтын үйл ажиллагаанд эгшиглүүлэн олон нийтэд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэхийг хөгжмийн зохиолч Б.Эрдэнэбаярт үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1,500,000 төгрөгийг Засаг даргын нөөцөөс зарцуулахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), ня-бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ